

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Хэрлэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: **ДОА-2025/006/НА-СТА-ТТЗ**

Цахим хуудас: www.audit.mn
Чойбалсан хот
2025 он

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 7056-2112, Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn
Аудитын менежер: И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Нармандах
Утас: 7058-4204, Цахим хаяг: narmandakh@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Батжаргал
Утас: 70584204 Цахим хаяг: batjargalb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4-10
5. Аудитын илрүүлэлт	19
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	20
7. Албан шаардлага.....	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2025.03.24 № 377

танай _____ -ны № _____ -т

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН
СУМЫН ЗАСАГ ДАРГА
С.МӨНХЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дорнод аймгийн Хэрлэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Дорнод аймгийн Хэрлэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагууд үйл ажиллагаа явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Дорнод аймгийн Хэрлэн сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 30-ны 03/01 дугаар тогтоолоор сумын 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг "Хангалттай" гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

232520377

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	6,694,935.0	9,038,596.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,694,392.0	6,640,849.9
33	АВЛАГА	1,050,703.7	1,045,053.2
35	БАРАА МАТЕРИАЛ	1,894,339.3	1,292,993.4
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	28,846,792.2	38,469,944.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	28,846,792.2	38,469,944.0
392	Биет хөрөнгө	25,797,898.3	33,468,842.9
393	Биет бус хөрөнгө	3,048,893.9	5,001,101.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	35,541,727.1	47,508,540.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	14,485.1	18,562.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	14,485.1	18,562.4
413	Өглөг	13,968.1	18,562.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	35,527,242.0	47,489,978.1
51	Засгийн газрын хувь оролцоо	35,527,242.0	47,489,978.1
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	10,516,460.1	10,516,460.1
512	Хуримтлагдсан үр дүн	24,456,648.7	36,419,384.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	554,133.2	554,133.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	35,541,727.1	47,508,540.5

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	36,601,224.4	50,911,013.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	17,382,064.6	27,339,005.1
110	Орлогын албан татвар	13,573,591.0	22,556,330.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	14,481,411.1	23,414,240.2
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(907,820.1)	(857,909.3)
113	Хөрөнгийн албан татвар	1,243,976.1	1,175,471.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	2,564,497.5	3,607,202.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,930,315.7	2,304,824.3
1181	Газрын төлбөр	634,181.8	1,302,378.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,650,763.1	16,819,652.4
120	Нийтлэг татварын бус орлого	12,643,263.1	16,813,652.4
122	Тусламжийн орлого	7,500.0	6,000.0
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,568,396.7	6,752,355.8
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	23,473,892.4	31,834,842.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	23,473,892.4	31,834,842.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,581,122.5	17,246,903.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,717,390.1	3,911,204.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	344,789.6	471,341.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	345,199.9	1,720,761.9
2104	Хангамж, бараа материалын зардал	531,475.0	589,421.3
2105	Нормативт зардал	37,904.3	39,095.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,049,605.9	589,462.4
2107	Томилголт, зочны зардал	932.7	3,720.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	3,036,365.2	1,504,449.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,517,459.9	8,417,447.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,892,769.9	14,587,939.3
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	13,127,332.0	19,076,170.9
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,575,544.0	7,113,434.8
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(2,575,544.0)	(7,113,434.8)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	10,551,788.0	11,962,736.1

Хэрлэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	22,470,375.5	0.0	22,470,375.5
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	22,835,454.0	0.0	22,835,454.0
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	35,527,242.0	0.0	35,527,242.0
D01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	35,527,242.0	0.0	35,527,242.0
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	35,527,242.0	0.0	35,527,242.0
D08	Тайлант үеийн үр дүн	10,962,736.1		10,962,736.1
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	46,489,978.1	0.0	46,489,978.1

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	27,331,636.7	37,387,550.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	17,382,064.6	27,339,005.1
110	Орлогын албан татвар	13,573,591.0	22,556,330.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	14,481,411.1	23,414,240.2
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(907,820.1)	(857,909.3)
113	Хөрөнгийн албан татвар	1,243,976.1	1,175,471.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	2,564,497.5	3,607,202.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,930,315.7	2,304,824.3
1181	Газрын төлбөр	634,181.8	1,302,378.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,526,318.9	3,744,367.6
120	Нийтлэг татварын бус орлого	3,518,818.9	3,738,367.6
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,715,073.3	3,221,977.2
122	Тусламжийн орлого	7,500.0	6,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,423,253.1	6,304,178.1
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	19,965,358.2	27,223,939.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	19,965,358.2	27,223,939.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,071,764.2	12,634,655.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,764,645.3	3,911,337.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	286,867.4	471,341.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	372,977.2	1,751,886.8
2104	Хангамж, бараа материалын зардал	486,136.1	566,654.0
2105	Нормативт зардал	39,554.1	25,358.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	257,057.2	294,395.1
2107	Томилголт, зочны зардал	956.0	3,720.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,041,200.4	1,509,776.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,822,370.4	4,100,185.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,893,594.0	14,589,284.5
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	7,366,278.5	10,163,611.1
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,264,783.4	7,177,153.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,264,783.4	7,177,153.2
2200	Дотоод эх үүсвэрээр	4,264,783.4	7,177,153.2
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(4,264,783.4)	(7,177,153.2)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	235,800.0	40,000.0
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	2,865,695.1	2,946,457.9
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	828,696.9	3,694,392.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,694,392.0	6,640,849.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,845,926.7	13,678,799.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,147,574.1	6,804,260.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,956,928.1	6,614,460.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,113,310.1	2,103,672.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	261,688.4	261,244.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,453,182.9	1,405,713.5
2104	Хангамж, бараа материалын зардал	45,514.8	43,952.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	178,397.0	177,672.6
2107	Томилолт, зочны зардал	7,136.0	3,720.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,327,054.5	1,327,046.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,570,644.4	1,291,438.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	190,646.0	189,799.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,398,352.6	6,834,538.3
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	300,000.0	40,000.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	14,845,926.7	13,831,555.9
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	11,359,705.5	13,610,361.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,469,521.2	217,444.9
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	16,700.0	3,750.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		109,978.1
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		368,379.4
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	183.0	183.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	13.0	13.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	85.0	85.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	85.0	85.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Данс...	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	380,217.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	380,217.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	379,217.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	172,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,337.67
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,084.18
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	120,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72,995.86
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	380,217.71
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	380,217.71

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 245.7 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 125.8 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 119.9 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

5.1 Албан шаардлага

1. Улс төрийн намуудад орон нутгийн төсвөөс хууль, тогтоомжид заагдаагүй 31.0 сая төгрөгийг олгохоор төлөвлөж, санхүүжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хууль 15 дугаар зүйлийн 15.1.3 “хууль тогтоомжид зааснаас өөр

**Хэрлэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтуудтай нийцээгүй тул албан шаардлага хүргүүлээ.

2. Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар Гадаадын иргэн, харьяатын газрын зүүн бүс дэх газарт 94.8 сая төгрөгөөр орон сууц худалдан авсан байна. Энэ нь Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан сумын чиг үүрэгт хамаарахгүй, мөн санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн

Илрүүлэлт:

Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 56 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 119.9 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ буюу 5 хувь нь хэрэгжээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.7-д “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, хүрэх үр дүнг бүрэн хангаж ажиллах зөвлөмж өглөө.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ”. Харин зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төлөвлөлтийг хууль, журмын дагуу хийгээгүй, зориулалт бус	1	31.0	-	-	1	31.0	-	-	-	-	-	-
Төсвийг чиг үүргийн бус зүйлд хөрөнгө оруулсан	1	94.8	-	-	1	94.8	-	-	-	-	-	-
Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, хүрэх үр дүнг бүрэн хангаж ажиллаагүй.	1	119.9	-	-	-	-	1	119.9	-	-	-	-
Дүн	3	245.7	-	-	2	125.8	1	119.9	-	-	-	-



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 01/200.2019-2025/006/НА-СТА-ТТЗ

Чойбалсан хот

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Хэрлэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улс төрийн намуудад орон нутгийн төсвөөс хууль, тогтоомжид заагдаагүй 31.0 сая төгрөгийг олгохоор төлөвлөж, санхүүжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хууль 15 дугаар зүйлийн 15.1.3 “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.6 “Төсвийг зориулалт бусаар зарцуулсан” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Улс төрийн намуудад орон нутгийн төсвөөс санхүүжилт олгодог зөрчлийг таслан зогсоож биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод аймгийн Хэрлэн сумын Засаг дарга С.Мөнхжаргал, санхүүгийн албаны дарга Г.Алтантогос нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР *Мунис* И.СЭМЖИДМАА

АХЛАХ АУДИТОР *Б.Батжаргал* Б.БАТЖАРГАЛ



2125040595



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 02/201 2019-2025/006/НА-СТА-ТТЗ Чойбалсан хот

Г Зөрчил арилгах тухай 7

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Хэрлэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар Гадаадын иргэн, харьяатын газрын зүүн бүс дэх газарт 94.8 сая төгрөгөөр орон сууц худалдан авсан байна.

Энэ нь Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан сумын чиг үүрэгт хамаарахгүй байна. Мөн Санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.6 "Төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Сумын төсвийг Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан сумын чиг үүрэгт нийцүүлэн төлөвлөж, зарцуулаагүй зөрчлийг арилган, биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод аймгийн Хэрлэн сумын Засаг дарга С.Мөнхжаргал, санхүүгийн албаны дарга Г.Алтантогос нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Шүлэг И.СЭМЖИДМАА

АХЛАХ АУДИТОР

Б.БАТЖАРГАЛ



2125040599

